



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 1/12

Арвайхээр

**Хот хоорондын тээврийн хэрэгслийн зорчих  
хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 08-ны 07 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Коронавируст халдварт (Ковид-19) цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрээс бусад аймаг, Улаанбаатар хотруу эрүүл мэндийн шалтгаантай, буяны үйл ажиллагаа, хүнс, шатахуун, түлээ нүүрс, малын тэжээлийн тээврээс бусад гарах болон орох авто тээврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 06.00 цагаас 03 дугаар сарын 20-ны өдрийн 06.00 цаг хүртэл хязгаарласугай.


2. Хархорин, Нарийнтээл сумдад бүртгэл хяналтын системийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллах албан хаагчдыг нэмж, мэргэжлийн анги, байгууллагуудаас томилж ажиллуулахыг дээрх сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Хужирт суманд үйл ажиллагаа явуулж буй рашаан сувиллуудад дээрх хугацаанд Улаанбаатар хот болон эрсдэлтэй бус нутгаас иргэдийг хүлээн авахгүй байх арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Хужирт сумын Засаг дарга (Т.Баярмөнх) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тус аймгаар дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг камерын системээр хянах ажлыг зохион байгуулан, хөдөлгөөний дэглэм зөрчсөн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нарт хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Төрийн үйлчилгээний нэгдсэн төв (Б.Анхтуяа)-д тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн нэгдүгээр заалтыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Автотээврийн төв (Д.Амартувшин), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

011100250